



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өлзийт сумын ИТХ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: АРА-2022/70/НА-СТА-ТШЗ**

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a></p> <p>2022 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор: Т.Байгалмаа Утас: 70333141 Цахим хаяг: Baigalmaa.T@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Д.Нэргүйбаатар Утас: 70332860 Цахим хаяг: Nerguibaatar.d@audit.gov.mn</p> <p>Аудитор: Г.Цог-Эрдэнэ Утас: 99210906 Цахим хаяг: Tsogerdene.g@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1. Аудитын дүгнэлт

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	11
3.4 Материаллаг байдал .....	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	13
3.8 Аудитын гол асуудал .....	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	13
Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан /Local.audit.mn сайтад шивсэн/ ба илэрсэн зөрчилд зөвлөмж хүргүүллээ.....	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
4. Аудитын илрүүлэлт .....	15
4.2 Албан шаардлага .....	15
4.3 Зөвлөмж .....	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	16
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	16

## Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль

## 1. АУДИТЫН ДҮГНЭЛТ



### АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

65130 Цэцэрлэг, Архангай аймаг  
Утас/Факс: 976-70333141  
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

Ауд. Д.д. 22 № 31  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

#### Аудитын санал дүгнэлт

##### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өлзийт сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Өлзийт сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

##### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалган дагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

##### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

##### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхгүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБӨУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	93,620.39	12,327.63
2	АВЛАГА	93,620.39	12,327.63
3	Ажиллагчидтай холбогдсон авлага	93,620.39	12,327.63
4	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,608,703.09	1,691,063.23
5	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,608,703.09	1,691,063.23
6	Биет хөрөнгө	2,608,703.09	1,691,063.23
7	Машин тоног төхөөрөмж(компьютер)	3,867,618	3,867,618
8	Хуримтлагдсан элэгдэл	-2,434,474.89	-2,792,617.96
9	Тавилга, аж ахуйн эд хогшил	7,459,957	7,459,957
10	Хуримтлагдсан элэгдэл	-6,284,397.02	-6,843,893.81
11	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,702,323.48	1,703,390.86
12	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,702,323.48	1,703,390.86
13	Засгийн газрын хувь оролцоо	2,702,323.48	1,703,390.86
14	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,239,505	2,239,505
15	Хуримтлагдсан үр дүн	390,386.01	-608,546.61
16	Өмнөх үеийн үр дүн	-26,215.06	390,386.01
17	Тайлант үеийн үр дүн	416,601.07	-998,932.62
18	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	72,432.47	72,432.47
19	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,702,323.48	1,703,390.86

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

№	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	74,086,900	59,078,900
2	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	74,086,900	59,078,900
3	Нэмэлт санхүүжилтийн орлого		420,000
4	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		420,000
5	Орон нутгийн төсвөөс санхүүжих	74,086,900	58,658,900
6	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	74,086,900	58,658,900
7	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	73,670,298.93	60,077,832.62
8	УРСГАЛ ЗАРДАЛ	73,670,298.93	60,077,832.62
9	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	61,223,098.93	60,077,832.62
10	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	46,053,000	45,705,554.35
11	Үндсэн цалин	46,053,000	45,705,554.35
12	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,123,679.61	6,574,438.41
13	Тэтгэврийн даатгал	4,281,379.61	4,876,725.25
14	Тэтгэмжийн даатгал	460,700	424,428.29
15	ҮОМШӨ-ний даатгал	368,400	339,542.61
16	Ажилгүйдлийн даатгал	92,100	163,713.56
17	Эрүүл мэндийн даатгал	921,100	770,028.7
18	Хангамж, бараа материалын зардал	5,581,800	2,486,700
19	Бичиг хэрэг	519,000	201,500
20	Тээвэр, шатахуун	3,338,200	2,036,200
21	Ном, хэвлэл	492,000	249,000
22	Аж ахуйн материал худалдан авах зардал	1,232,600	
23	Томилолт, зочны зардал	144,000	200,000
24	Дотоод албан томилолт	144,000	200,000
25	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	783,600	
26	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	261,800	
27	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	150,000	
28	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	371,800	
29	Бараа үйлчилгээний бусад зардал	2,537,019.32	5,111,139.86
30	Бараа үйлчилгээний бусад зардал	1,150,000	3,224,000
31	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	60,000	969,500
32	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,327,019.32	917,639.86
33	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,447,200	
34	Бусад урсгал шилжүүлэг	11,791,200	
35	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	11,691,200	
36	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	100,000	
37	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	656,000	
38	Төвлөрүүлэх шилжүүлэг	656,000	
39	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	416,601.07	-998,932.62
40	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	416,601.07	-998,932.62

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,239,505	72,432.47	-26,215.06	2,285,722.41
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,239,505	72,432.47	-26,215.06	2,285,722.41
3	Тайлант үеийн үр дүн			416,601.07	416,601.07
4	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,239,505	72,432.47	390,386.01	2,702,323.48
5	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,239,505	72,432.47	390,386.01	2,702,323.48
6	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,239,505	72,432.47	390,386.01	2,702,323.48
7	Тайлант үеийн үр дүн			-998,932.62	-998,932.62
8	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	2,239,505	72,432.47	-608,546.61	1,703,390.86

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	өмнөх он	тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	74,086,900	59,078,900
2	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	74,086,900	59,078,900
3	Нэмэлт санхүүжилтийн орлого		420,000
4	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		420,000
5	Орон нутгийн төсвөөс санхүүжих	74,086,900	58,658,900
6	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	74,086,900	58,658,900
7	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	72,436,900	59,078,900
8	УРСГАЛ ЗАРДАЛ	72,436,900	59,078,900
9	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	59,989,700	59,078,900
10	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	46,053,000	45,549,500
11	Үндсэн цалин	46,053,000	45,549,500
12	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,217,300	6,649,200
13	Тэтгэврийн даатгал	4,375,000	4,827,200
14	Тэтгэмжийн даатгал	460,700	455,500
15	ҮОМШӨ-ний даатгал	368,400	364,400
16	Ажилгүйдлийн даатгал	92,100	91,100
17	Эрүүл мэндийн даатгал	921,100	911,000
18	Хангамж, бараа материалын зардал	3,634,000	2,536,200
19	Бичиг хэрэг	360,000	300,000
20	Тээвэр, шатахуун	2,650,000	2,036,200
21	Ном, хэвлэл	624,000	200,000
22	Томилолт, зочны зардал	144,000	200,000
23	Дотоод албан томилолт	144,000	200,000
24	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,521,800	
25	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,000,000	
26	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	150,000	
27	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	371,800	
28	Бараа үйлчилгээний бусад зардал	2,419,600	4,144,000
29	Бараа үйлчилгээний бусад зардал	1,679,800	3,224,000
30	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	739,800	920,000
31	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,447,200	
32	Бусад урсгал шилжүүлэг	11,791,200	
33	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	11,691,200	
34	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	100,000	
35	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	656,000	
36	Төвлөрүүлэх шилжүүлэг	656,000	
37	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,650,000	
38	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	1,650,000	
39	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,650,000	
40	Дотоод эх үүсвэрээр	1,650,000	
41	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,650,000	
42	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-1,650,000	
43	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)		
44	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0
45	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	0

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИИТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	58,658,900	58,658,900	-	100
2	УРСГАЛ ЗАРДАЛ	58,658,900	58,658,900	-	100
3	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	58,658,900	58,658,900	-	100
4	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	45,549,500	45,549,500	-	100
5	Үндсэн цалин	45,549,500	45,549,500	-	100
6	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,649,200	6,649,200	-	100
7	Тэтгэврийн даатгал	4,827,200	4,827,200	-	100
8	Тэтгэмжийн даатгал	455,500	455,500	-	100
9	ҮОМШӨ-ний даатгал	364,400	364,400	-	100
10	Ажилгүйдлийн даатгал	91,100	91,100	-	100
11	Эрүүл мэндийн даатгал	911,000	911,000	-	100
12	Хангамж, бараа материалын зардал	2,536,200	2,536,200	-	100
13	Бичиг хэрэг	300,000	300,000	-	100
14	Тээвэр, шатахуун	2,036,200	2,036,200	-	100
15	Ном, хэвлэл	200,000	200,000	-	100
16	Томилолт, зочны зардал	200,000	200,000	-	100
17	Дотоод албан томилолт	200,000	200,000	-	100
18	Бараа үйлчилгээний бусад зардал	3,724,000	3,724,000	-	100
19	Бараа үйлчилгээний бусад зардал	3,224,000	3,224,000	-	100
20	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	500,000	500,000	-	100
21	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	58,658,900	58,658,900	-	100
22	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	57,158,900	58,658,900	(1,500,000)	103
23	Орон нутгийн төсвөөс	57,158,900	58,658,900	(1,500,000)	103
24	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,500,000		1,500,000	-
25	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	1,500,000		1,500,000	-
26	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100
27	Төсвийн байгууллага	1	1	-	100
28	АЖИЛЛАГСАДЫН ТОО	2	2	-	100

29	Удирдах ажилтан	2	2	-	100
----	-----------------	---	---	---	-----

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

№	Үзүүлэлт	/ төгрөг /
1	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	420,000.00
2	УРСГАЛ ЗАРДАЛ	420,000.00
3	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	420,000.00
4	Бараа үйлчилгээний бусад зардал	420,000.00
5	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	420,000.00
6	Нэмэлт санхүүжилтийн орлого	420,000.00
7	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	420,000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Өлзийт сумын ИТХ нь 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад шилэн дансны хууль тогтоомжийг мөрдөн мэдээллийг хуулинд заасан хугацаанд Шилэн дансаар олон нийтэд мэдээлж хэвшихтэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Цог-Эрдэнэ гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Өлзийт сумын ИТХ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 21 -ны өдрийн 02 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Өлзийт сумын ИТХ нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1-д “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал ажлын албатай байна”, 54.2-д “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны бүтэц, орон тоо, цалингийн санг Засгийн газраас тогтоосон хязгаарын хүрээнд Хурал өөрөө тогтооно”, 54.3-д “Ажлын албаны дарга нь тухайн Хурлын нарийн бичгийн дарга байх бөгөөд орон тооны байна” гэж заасны дагуу харьяалах нутаг дэвсгэртээ үйл ажиллагаа явуулдаг, аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллага юм.

Тус байгууллага нь тайлант онд *“Иргэд сонгогчдын итгэл найдвар ашиг сонирхолыг дээдлэн нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхыг дээшлүүлэхийн тулд эв нэгдэл, хяналт шалгалт, сахилга хариуцлага, шударга ёсыг чанд сахин ажиллах”* гэсэн зорилт тавин ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын нэгжгүй хяналт хэрэгжүүлээгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд Санхүүгийн хяналт, аудитын албанаас төлөвлөгөөт хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өлзийт сумын ИТХ нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 58.6 сая төгрөгөөс 1 хувиар буюу 0.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 70 хувиар буюу 0.4 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн эхний үлдэгдлээс 1.0 сая төгрөгөөр буюу 36.9 хувиар буурч материаллаг өөрчлөлт гарсан нь авлага, үндсэн хөрөнгийн дансууд байна.

Хүснэгт 1. Санхүү байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/сая.төгрөгөөр/			
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	Хувь
Авлага	0.09	0.01	(0.08)	(86.86)
Үндсэн хөрөнгө	2.61	1.69	(0.92)	(35.16)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>2.70</b>	<b>1.70</b>	<b>(1.00)</b>	<b>(36.95)</b>
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2.70	1.70	(1.00)	(36.97)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>2.70</b>	<b>1.70</b>	<b>(1.00)</b>	<b>(36.97)</b>

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Авлагын үлдэгдэл 86.6 хувиар буурсан байна.

Авлагын данс нь 0.09 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд авлага 0.08 сая төгрөгөөр буурч оны эцэст 0.01 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 35.1 хувиар буурсан байна. Үндсэн хөрөнгө данс нь 2.6 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд нэмэгдсэн, хасагдсан хөрөнгө байхгүй ба байгуулсан 0.9 сая төгрөгийн элэгдлээр буурч оны эцэст 1.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.
- Цэвэр хөрөнгө өмчийн дүн буурсан нь тайлант хугацааны үр дүн 0.9 сая төгрөгөөр буурсантай холбоотой.

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Өөрчлөлт / сая.төгрөгөөр/
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт -/орон нутгийн төсөв/	74.09	58.66	-15.43
Нэмэлт санхүүжилтийн орлого	-	0.42	0.42
<b>Үйл ажиллагааны орлого</b>	<b>74.09</b>	<b>59.08</b>	<b>-15.01</b>
Цалин, шимтгэлийн зардал	52.18	52.28	0.1
Бусад бараа үйлчилгээний зардал	9.05	7.8	-1.25
Урсгал шилжүүлэг	12.45	-	-12.45
<b>Үйл ажиллагааны зардал</b>	<b>73.67</b>	<b>60.08</b>	<b>-13.59</b>
<b>Үйл ажиллагааны бус зардал /ҮХХ-ны гарз/</b>	<b>0</b>		
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>0.42</b>	<b>-1</b>	<b>-1.42</b>

Өлзийт сумын ИТХ-ын санхүүгийн үр дүнгийн тайлангийн урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн орлого өмнөх оноос 15.3 сая төгрөгөөр буюу 20.8 хувиар буурсан нь хангамжийн бараа материалын зардал 55.4 хувиар, урсгал шилжүүлэг 100 хувиар тус тус буурсантай холбоотой байна. Төлөвлөсөн санхүүжилтийг зарцуулж ажилласан байна.

**3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зардлыг 60.1 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлжээ.

Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг нийт 3.0 сая төгрөгөөр бууруулж, зардлыг 57.1 сая төгрөгөөр хянаж баталсан байна. Харин тайлант онд батлагдсан төсвийн дүнг 2.5 хувиар буюу 58.6 сая төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгожээ. Төсөв нэмэгдүүлсэн шалтгаан нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал 1.5 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

**3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагч 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 58.6 сая төгрөгийн төсөв батлагдсан. Гүйцэтгэлээр санхүүжилтийг бүрэн авч, 100 хувь зарцуулалт хийсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

**3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар 0.4 сая төгрөгийн орлого төвлөрч сумын ИТХ-ын төлөөлөгчдийг чадавхижуулах сургалтанд зарцуулсан байна.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 12 дугаар сарын 24-ны өдөр Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсан ба 2022 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөж эхэлсэн байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тус байгууллага нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан стратегийн зорилтуудыг хангахад чиглэсэн 5 үндсэн зорилтын хүрээнд 13 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 92 хувьтай байна.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд 58.6 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөснөөс хэрэгжилт 100 хувийн биелэлттэй байна.

Аудитын явцад санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үнэллээ. Үүнд:

1. Төсвийн хэмнэлтийн талаар авсан арга хэмжээ, түүний үр дүн судалгааг авч үзэхэд орон тоо нэмэгдүүлээгүй, шагнал урамшуулал олгоогүй, автомашин, албан конторын тавилга, албаны болон дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж хэрэгсэл худалдан аваагүй байна.

Харин бусад судалгаанд холбогдох мэдээлэлгүй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан /Local.audit.mn сайтад шивсэн/ ба илэрсэн зөрчилд зөвлөмж хүргүүллээ.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Өлзийт сумын ИТХ нь 2021 онд нийт 2.0 сая төгрөгийн 141 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 2.0 сая төгрөгийн 121 мэдээллийг хугацаанд нь ил тод байршуулж, 20 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, өмнөх аудитаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй алдаа зөрчлийг давтан гаргасан байна.

Шийдвэрлэсэн нь: *Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэх*

### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

1. Тайланд онд Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллахыг бүх шатны төсөв захирагчид даалгасан. Төсвийн хэмнэлтийг тогтоолын 1.1-д заасан үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, арга хэмжээг тэвчиж, зардал гаргахгүй байх, батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гарахаар тооцож, урсгал болон хөрөнгийн зардлыг төлөвлөн хуваарилах гэсэн заалттай нийцүүлж үзэхэд 10% буюу 0.6 сая төгрөгийн хэмнэлтийг бий болгоогүй байна.

Шийдвэрлэсэн нь: *Засгийн газрын 2021 оны Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай 43-р тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах албан шаардлагыг хүргүүлэх*

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй, бусад хууль тогтоомжийн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилты холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийгээгүй, шилэн дансны мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан зөрчил илэрсэнд дотоод хяналтыг тогтмол хэрэгжүүлж үр дүнг тооцож ажиллах, шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах 2 заалт бүхий зөвлөмж хүргүүлснийг хэрэгжүүлээгүйд албан шаардлага хүргүүлж байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

МУЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажилласан эсэхийг шалгах нь зүйтэй байна.

#### 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 0.6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 0.6 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлэн, 1 заалт бүхий зөвлөмж өглөө.

##### 4.2 Албан шаардлага

- Тус байгууллага нь 2021 оны байгууллагын үйл ажиллагаа болон санхүү, төсвийн гүйцэтгэлд дотоод хяналт шалгалт хийгдээгүй, өмнөх аудитаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй алдаа зөрчлийг давтан гаргасан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4 -д “ төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 39 дүгээр зүйлийн 39.4.2-д “өр, авлага үүсгэхгүй байх” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4 дэх заалтын дагуу төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг хийх, хяналт шалгалтаар өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг үнэлж, үр дүнг тооцож ажиллах албан шаардлага хүргүүлэх

##### 4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

###### 1. Авлагатай холбоотой асуудал

Тус байгууллага нь 2021 онд 12.3 мянган төгрөгийн авлага үүсгэсэн байна.

###### Өгсөн зөвлөмж:

*Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь заалтын хэрэгжилтийг хангаж ажиллах, авлага, өр төлбөрийг барагдуулах*

-----oOo-----

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа зөрчлийн утга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс								
					Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал													
1	Өлзийт сумын ИТХ	Тус байгууллага нь 2021 онд 12.3 мянган төгрөгийн авлага үүсгэсэн	1	0.01							1	0.01	
2		2021 оны байгууллагын үйл ажиллагаа болон санхүү, төсвийн гүйцэтгэлд дотоод хяналт шалгалт хийгдээгүй, өмнөх аудитаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй алдаа зөрчлийг давтан гаргасан	1							1			
Дүн			2	0.01						1		1	0.01
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал													
1	Өлзийт сумын ИТХ	МУЗГ-ын 43 дугаар тогтоолын хэрэгжилт 10% буюу 0.6 сая төгрөгийн хэмнэлтийг бий болгоогүй байна	1	0.6						1	0.6		
2		20 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, өмнөх аудитаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй алдаа зөрчлийг давтан гаргасан.	1							1			
Дүн			2	0.6						2	0.6		
Нийт дүн			4	0.6						3	0.6	1	0.01